| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар                                                  | -                    | 279,400.00           |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо                                               | -                    | 114,200.00           |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                             |                      | 320,800.00           |
| 210807      | Газрын төлбөр                                                               |                      | 47,400.00            |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                                      |                      |                      |
|             |                                                                             | 6,325,542.00         | 4,568,900.00         |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                             | 6,325,542.00         | 4,568,900.00         |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                                     | <b>10,566,263.00</b> | <b>42,000,000.00</b> |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                               |                      |                      |
|             |                                                                             | -                    | 42,000,000.00        |
| 213204      | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал                              |                      | 42,000,000.00        |
| <b>2133</b> | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                          |                      |                      |
|             |                                                                             | 7,863,758.00         | -                    |
| 213303      | Төвлөрүүлэх шилжүүлэг                                                       | 7,863,758.00         | -                    |
| <b>2134</b> | <b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b> |                      |                      |
|             |                                                                             | 2,702,505.00         | -                    |
| 213403      | Төвлөрүүлэх шилжүүлэг                                                       | 2,702,505.00         | -                    |

|        |                                                                     |                 |                        |
|--------|---------------------------------------------------------------------|-----------------|------------------------|
| 3      | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)                    | <u>5,856.14</u> | <u>12,450,000.00</u>   |
| 5      | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)                           | -               | 12,450,000.00          |
| 22     | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ                                                    | -               | 12,450,000.00          |
| 2200   | Дотоод эх үүсвэрээр                                                 | -               | 12,450,000.00          |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал                      | -               | 12,450,000.00          |
| 6      | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>-</u>        | <u>(12,450,000.00)</u> |
| 7      | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ                     | <u>-</u>        | <u>-</u>               |
| 8      | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)                           | 5,856.14        | -                      |
| 9      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                    | -               | 5,856.14               |
| 10     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                   | 5,856.14        | -                      |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт                                         | Тайлант оны           |                |
|-----------------------|--------------------------------------------------|-----------------------|----------------|
|                       |                                                  | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл      |
| 1                     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл |                       |                |
| 2                     | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                | 623,127,900.00        | 590,525,660.00 |
| 21                    | УРСГАЛ ЗАРДАЛ                                    | 623,127,900.00        | 590,525,660.00 |
| 210                   | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                  | 623,127,900.00        | 590,525,660.00 |
| 2101                  | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                | 424,119,800.00        | 391,517,561.08 |
| 210101                | Үндсэн цалин                                     | 255,622,800.00        | 208,473,181.99 |
| 210102                | Нэмэгдэл                                         | 97,396,100.00         | 113,632,241.55 |
| 210103                | Унаа хоолны хөнгөлөлт                            | 7,560,000.00          | 5,871,237.54   |
| 210104                | Урамшуулал                                       | 38,343,400.00         | 38,343,400.00  |
| 210105                | Гэрээт ажлын хөлс                                | 25,197,500.00         | 25,197,500.00  |
| 2102                  | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл   | 57,256,200.00         | 57,256,200.00  |

|             |                                                                      |               |               |
|-------------|----------------------------------------------------------------------|---------------|---------------|
| 210201      | Тэтгэврийн даатгал                                                   | 40,291,400.00 | 40,291,400.00 |
| 210202      | Тэтгэмжийн даатгал                                                   | 4,241,200.00  | 4,241,200.00  |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал                                                    | 3,392,900.00  | 3,392,900.00  |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал                                                 | 848,300.00    | 848,300.00    |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал                                                | 8,482,400.00  | 8,482,400.00  |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | 27,208,800.00 | 27,208,800.00 |
| 210301      | Гэрэл, цахилгаан                                                     | 1,837,700.00  | 1,837,700.00  |
| 210302      | Түлш, халаалт                                                        | 25,371,100.00 | 25,371,100.00 |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | 34,469,300.00 | 34,469,298.92 |
| 210401      | Бичиг хэрэг                                                          | 2,798,400.00  | 3,197,400.00  |
| 210402      | Тээвэр, шатахуун                                                     | 25,451,900.00 | 25,011,898.92 |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 1,200,000.00  | 1,305,000.00  |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал            | 3,267,200.00  | 3,203,200.00  |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 1,751,800.00  | 1,751,800.00  |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>                                              | 55,456,000.00 | 55,456,000.00 |
| 210501      | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                                      | 39,420,200.00 | 39,420,200.00 |
| 210502      | Хоол, хүнс                                                           | 10,988,600.00 | 10,988,600.00 |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл                                          | 5,047,200.00  | 5,047,200.00  |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | 14,118,400.00 | 14,118,400.00 |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл                                              | 13,301,800.00 | 13,301,800.00 |
| 210604      | Урсгал засвар                                                        | 816,600.00    | 816,600.00    |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>                                        | 2,528,300.00  | 2,528,300.00  |
| 210702      | Дотоод албан томилолт                                                | 2,528,300.00  | 2,528,300.00  |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | 3,402,200.00  | 3,402,200.00  |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,120,000.00  | 2,120,000.00  |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 360,000.00    | 360,000.00    |
| 210803      | Даатгалын үйлчилгээ                                                  | 160,400.00    | 160,400.00    |

|             |                                                               |                       |                       |
|-------------|---------------------------------------------------------------|-----------------------|-----------------------|
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар                                    | 279,400.00            | 279,400.00            |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо                                 | 114,200.00            | 114,200.00            |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                               | 320,800.00            | 320,800.00            |
| 210807      | Газрын төлбөр                                                 | 47,400.00             | 47,400.00             |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                        | 4,568,900.00          | 4,568,900.00          |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                               | 4,568,900.00          | 4,568,900.00          |
| <b>13</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                         | <b>623,127,900.00</b> | <b>590,525,660.00</b> |
| <b>1310</b> | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                | 557,816,600.00        | 557,816,600.00        |
| 131007      | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих                      | <b>557,816,600.00</b> | 557,816,600.00        |
| 131008      | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих               |                       |                       |
| <b>1320</b> | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                         | 28,025,400.00         | 28,025,400.00         |
| 132001      | Орон нутгийн төсвөөс                                          | <b>28,025,400.00</b>  | <b>28,025,400.00</b>  |
| <b>1340</b> | <b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>           | 37,285,900.00         | 4,683,660.00          |
| 134002      | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих                     | <b>37,285,900.00</b>  | 4,683,660.00          |
| <b>62</b>   | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>                                       | 30.00                 | 38.00                 |
| 620001      | Удирдах ажилтан                                               | 1.00                  | 1.00                  |
| 620002      | Гүйцэтгэх ажилтан                                             | 21.00                 | 23.00                 |
| 620003      | Үйлчлэх ажилтан                                               | 8.00                  | 12.00                 |
| 620004      | Гэрээт ажилтан                                                |                       | 2.00                  |
| <b>65</b>   | <b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>                                    | <b>30.00</b>          | <b>38.00</b>          |
| 650008      | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 22.00                 | 24.00                 |
| 650009      | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)                    | 8.00                  | 12.00                 |
| 650010      | Гэрээт ажилтан                                                |                       | 2.00                  |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

|            |          |          | Төгрөгөөр |
|------------|----------|----------|-----------|
| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |

|             |                                                                                                             |                       |                       |
|-------------|-------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------|-----------------------|
|             | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>                                                     |                       |                       |
| <b>I</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                                                                    | <b>126,687,242.00</b> | <b>126,687,242.00</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                                                                        | <b>126,687,242.00</b> | <b>126,687,242.00</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                                                                      |                       |                       |
|             |                                                                                                             | 84,687,242.00         | 84,687,242.00         |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                                                                    |                       |                       |
|             |                                                                                                             | 19,370,500.00         | 19,370,500.00         |
| 210101      | Үндсэн цалин                                                                                                | 10,000,000.00         | 10,000,000.00         |
| 210102      | Нэмэгдэл                                                                                                    | 9,370,500.00          | 9,370,500.00          |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                                                                     |                       |                       |
|             |                                                                                                             | 14,165,200.00         | 14,165,200.00         |
| 210401      | Бичиг хэрэг                                                                                                 | 954,000.00            | 954,000.00            |
| 210402      | Тээвэр, шатахуун                                                                                            | 12,885,200.00         | 12,885,200.00         |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                                                          | 280,000.00            | 280,000.00            |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал                                                   | 46,000.00             | 46,000.00             |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                                                                 |                       |                       |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>                                                                                     |                       |                       |
|             |                                                                                                             | 43,080,711.00         | 43,080,711.00         |
| 210501      | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                                                                             | 34,935,711.00         | 34,935,711.00         |
| 210502      | Хоол, хүнс                                                                                                  | 2,020,000.00          | 2,020,000.00          |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл                                                                                 | 6,125,000.00          | 6,125,000.00          |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                                                                    |                       |                       |
|             |                                                                                                             | 7,540,000.00          | 7,540,000.00          |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл                                                                                     | 7,540,000.00          | 7,540,000.00          |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>                                                                               |                       |                       |
|             |                                                                                                             | 530,831.00            | 530,831.00            |
| 210702      | Дотоод албан томилолт                                                                                       | 530,831.00            | 530,831.00            |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                                                                     |                       |                       |
|             |                                                                                                             | 42,000,000.00         | 42,000,000.00         |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                                                               |                       |                       |
|             |                                                                                                             | 42,000,000.00         | 42,000,000.00         |
| 213204      | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал                                                              | 42,000,000.00         | 42,000,000.00         |
| <b>II</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                                                       | <b>105,387,242.00</b> | <b>126,687,242.00</b> |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>                                                                          |                       |                       |
|             |                                                                                                             | 105,387,242.00        | 126,687,242.00        |
| 131103      | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө |                       | 21,300,000.00         |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө  | 104,371,627.00        | 104,371,627.00        |

|           |                                                                              |              |              |
|-----------|------------------------------------------------------------------------------|--------------|--------------|
| 131105    | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,015,615.00 | 1,015,615.00 |
| <b>IV</b> | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>                              |              |              |
|           | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                             |              |              |
|           | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                            |              |              |

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 14 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн зорилго нь: Үйлчлэх хүрээний хүн амьд эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээг жигд, чанартай, хүртээмжтэй үзүүлэхэд оршино. Ард иргэдэд хүлээгдэл, чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх, чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төв нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас баримтын шалгалт хийгдээгүй байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийн сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 607.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 6.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 63.4 сая төгрөгөөр буюу 6.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт                                          | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл  | Өөрчлөлт        |
|---------------------------------------------------|------------------|------------------|-----------------|
| Б                                                 | 1                | 2                | 3=2-1           |
| Мөнгөн хөрөнгө                                    | 5856.1           | -                | -               |
| Авлага                                            | 6,997.0          | 26,600.0         | 19,603.0        |
| Урьдчилгаа                                        | -                | -                | -               |
| Бараа материал                                    | 51,037.2         | 75,923.5         | 24,886.3        |
| Үндсэн хөрөнгө                                    | 863,024.0        | 881,959.8        | 18,935.8        |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>921,064.0</b> | <b>984,483.4</b> | <b>63,419.4</b> |
| Өр төлбөр                                         | 23,728.8         | 22,948.5         | -780.3          |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 897,335.2        | 961,534.9        | 64,199.7        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>921,064.0</b> | <b>984,483.4</b> | <b>63,419.4</b> |

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Авлагын данс оны эхэнд 7.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба оны эцэст 26.6 сая төгрөг болж 19.6 сая төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас ковид 19 цар тахлын үеэр улаан бүсэд ажилласан эмч, ажилтнуудын урамшуулал хөлсний 26.6 сая төгрөгийн санхүүжилтийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 75.9 сая төгрөг болж 24.9 сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 147.8 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, аймгийн Эрүүл мэндийн газраас 13.5 сая төгрөгийн бараа материалыг орлого авч, 130.9 сая төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулж, 1.5 сая төгрөгийн эм, 4.0 сая төгрөгийн бараа материал, бүгд 5.5

сая төгрөгийг бараа материалын байгууллагын даргын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 06, 07 дугаар тушаалаар акталж зохих журмын дагуу устгалт хийсэн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1.040.2 сая төгрөг болж 25.3 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 12.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, ЭМЯ-наас 7.1 сая төгрөгийн, Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас 13.2 сая төгрөгийн, аймгийн ЭМГ-аас 3.8 сая төгрөгийн, НҮБ-ийн Хүн амын сангаас 4.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, сумын ОНХС-гаас эмнэлгийн нярайн ургийн хэмжигч төхөөрөмж 4.7 сая төгрөгийн, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 4 ширхэг 7.9 сая төгрөгийн мотоцикл, нийт 40.8 сая төгрөгийн үнэ төлбөргүй үндсэн хөрөнгийг орлогод авч, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 09 дугаар сарын 02-ны өдрийн 69 тоот тогтоолоор 27.9 сая төгрөгийн 2 ширхэг авто тээврийн хэрэгслийг акталж, үндсэн хөрөнгөд 21.6 сая төгрөгийн элэгдэл байгуулсан нь нөлөөлжээ.

Оны эхний 23.7 сая төгрөгийн өглөгөөс 0.8 сая төгрөгийн өглөгийг барагдуулж, оны эцэст эм, эмнэлгийн хэрэгсэлтэй холбоотой 18.0 сая төгрөгийн, ажилчидтай холбоотой 4.9 сая төгрөгийн, нийт 22.9 сая төгрөгийн өр шинээр үүссэн байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 961.5 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 64.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны төсвийг 623.1 сая төгрөгөөр баталсан ба тодотголоор өөрчлөлт ороогүй байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант 623.1 сая төгрөгийн санхүүжилт орлого хүлээн авахаас гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 557.8 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 28.0 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 4.6 сая төгрөгийн, нийтдээ 590.5 сая төгрөгийн санхүүжилтийг үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 37.3 сая төгрөгийн санхүүжилт авахаас 32.6 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан байна.

Төсвийн нийт зарлагын 38.1 хувийг ажиллагсадтай холбоотой зардал, 61.9 хувийг бусад бараа үйлчилгээний зардал эзэлж байна.

Шүүхийн 2021 оны 11 дугаар сарын 08-ны өдрийн дугаар 130/Шi2021/00842 тоот ажилгүй байсан хугацааны цалинг нөхөн төлүүлэх тухай захирамжаар төсвөөс захирамжийн дагуу нэг хүнд 1.3 сая төгрөгийг төлсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нийт 126.7 сая төгрөгийн санхүүжилт болон бусад орлогыг нэмэлт дансаар хүлээн авсан байна. Үүнд: 1.0 сая төгрөгийг, аймгийн Эрүүл мэндийн газраас Эрүүл

мэндийн сайдын 2021 оны А/496 , А/585 тоот тушаалуудаар Ковид-19-ын эрсдэлээс сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн салбарын ажилтнуудын урамшуулалд 62.4 сая төгрөгийн, нэг удаагийн тэтгэмжид 42.0 сая төгрөгийн, аймгийн Засан даргын нөөц хөрөнгөөс 21.3 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, урьд оны авлагаас 7.0 сая төгрөгийг барагдуулсан байна.

Үүнээс ковид-19 цар тахлын үед ажилласан ажиллагсадын цалин, урамшилд 19.4 сая, бичиг хэрэгт 0.9 сая, тээвэр шатахуунд 12.9 сая, шуудан холбоо интернетийн мөнгөд 0.3 сая, эм, эмнэлгийн хэрэгсэлд 35.0 сая, хоол хүнсэнд 2.0 сая, нормын хувцас, зөөлөн эдлэл 6.1 сая төгрөг, багаж, техник, хэрэгсэл 7.5 сая төгрөг, дотоод албан томилолт 0.5 сая, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшалд 42.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн төсвөөс Шүүхийн 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн дугаар 130/ШЗ2021/01368 захирамжаар Эрүүл мэндийн даатгалын сангаас 2019 онд олгосон өдрийн эмчилгээний санхүүжилтийг буцаан төлүүлэх тухай захирамжаар 16.2 сая төгрөгийг төлсөн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар Толбо сумын Эрүүл мэндийн төвийн аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд 2021 оны санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл гараагүй байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 651.5 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 651.5 сая төгрөгийн 106 мэдээллийг хугацаандаа байршуулж, 11 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээлэл байршуулах хугацаа нь болоогүй байна.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий бүх орлогын гүйлгээнд улсын төсвийн санхүүжилтийн 651.5 сая төгрөгийн 12 гүйлгээний мэдээллийг хугацаанд, өр, авлага үүсгэсэн нийт 49.5 сая төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилт 85.0 хувьтай хэрэгжсэн байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын 0.9 сая төгрөгийн гүйлгээг шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчилд албан шаардлаг ,нэг зөвлөмж өгсөн байна.

### **3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ**

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй. Харин цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж үндсэн болон нэмэлт дансны санхүүжилтийн зарцуулалтын тооцоог бүрэн шалгах боломжгүй тул гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах нь зүйтэй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 107.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 16.2 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлж, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой 41.9 сая төгрөгийн зөрчилд 1, шилэн данстай холбоотой 49.5 сая төгрөгийн зөрчилд 1, бүгд 2 зөвлөмж өгсөн.

### **4.1 Залруулсан алдаа**

4.1 Аудитаар 253.4 сая төгрөгийн зөрчлийг залруулав. Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргахдаа төсвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 126.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийг 126.7 сая төгрөгөөр тус тус илүү тайлагнасныг залруулав.

### **4.2 Төлбөрийн акт**

Тогтоосон төлбөрийн акт байхгүй

### **4.3 Албан шаардлага**

Байхгүй

### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

## 1. Шилэн дансны хэрэгжилтэй холбоотой асуудал

### 1.1. Илрүүлэлт:

1.Баяннуур сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд шилэн дансны 11 мэдээллийг хугацаа хоцроож, өр, авлага үүсгэсэн нийт 49.5 сая төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй шилэн дансны мэдээллийг мэдээлсэн байдал 85.0 хувьтай хэрэгжсэн байна.

### 1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх.

## 2. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал

### 2.1. Илрүүлэлт:

Тайлан онд нийт 37.8 сая төгрөгийн зардлыг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

### 2.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.2, 14.3.3, 20.2, 20.2.5, 20.2.6 дахь заалтуудыг мөрдөж худалдан авсан бараа материалыг шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгах, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал, зааврыг мөрдөж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн |       | Үүнээс    |       |               |     |                 |     |         |      |
|-----|-------------------------------------|----------------------|-------|-----------|-------|---------------|-----|-----------------|-----|---------|------|
|     |                                     |                      |       | Залруулга |       | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |      |
|     |                                     | Тоо                  | Дүн   | Тоо       | Дүн   | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн  |
|     | Баяннуур сумын Эрүүл мэндийн төв    | 3                    | 340.7 | 1         | 253.4 |               |     |                 |     | 2       | 87.3 |